
Хагас жилийн тайлан 2015

Нэр: “Хөдөө аж ахуйн бирж” ХХК

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамж – 37, GB Plaza

Утас: 7011-8779, 7012-8779, 7012-8775, 7012-8776, 7014-8779

Факс: 7013-8779

Веб хаяг: www.mce.mn

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог хөгжүүлэх, тэдгээр бараа бүтээгдэхүүнийг биржээр арилжиж эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн үндсийг бий болгох зорилгоор 2011 онд Монгол Улсын Их Хурлаас “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийг баталсан. Тус хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2013 онд Монгол Улсын Засгийн газрын 30 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 45 дугаар тогтоол тус тус гарснаар “Хөдөө аж ахуйн бирж” ХХК үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхэлсэн.

Байгуулагдсанаас хойш 2 жил гаруйн хугацаанд ижил төстэй биржүүдийн үйл ажиллагааг судалж өөрийн үйл ажиллагаанд тусгах, Монгол Улсын хууль эрх зүйн орчинд нийцүүлэн ажиллах, бараа, түүхий эдийн чанар, стандартыг мөрдүүлэх, гишүүн брокерын компаниудыг мэргэшүүлэн сургах, орон нутгаас арилжаа хийх боломжийг нээх зэрэг томоохон ажлуудыг амжилттай гүйцэтгэлээ.

Мөн малчид, тариаланчид, хоршоодыг биржийн арилжаанд идэвхтэй оролцуулах, түүхий эд бэлтгэлийг чанаржуулах зорилгоор орон нутагт ажиллаж, мэдээ, мэдээлэл, дэлгэрэнгүй таницуулгыг тогтмол хийж байна.

Төрийн өмчийн хорооны 2015 оны 03 сарын 26-ны өдрийн 180 тоот тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилсон

бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ХХААЯ-ны газрын дарга Л.Чой-Иш, гишүүдээр Төрийн өмчийн хорооны ахлах мэргэжилтэн Х.Володя, Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн Ш.Энх-Амар, Аж үйлдвэрийн яамны мэргэжилтэн Б.Батцэцэг, Сангийн яамны мэргэжилтэн С.Тулга, “Нью Майнинг ресоурсэс” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Төгөлдөр нар ТУЗ-ийн гишүүнээр тус тус томилогдон ажиллаж байгаа бол ТУЗ-ийн хараат бус гишүүд өөрчлөгдөөгүй болно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ХХААЯ-ны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын ХАА-н маркетинг, ХАА-н биржийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Оюун-Эрдэнэ ажиллаж байна.

Биржийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэнээс хойш биржийн үйл ажиллагаа, арилжаа явуулахад шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгасан Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам болон шимтгэл, хураамжийн хувь хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд шинэчлэн батлалаа.

2015 оны эхний хагас жилийн байдлаар нийт 298.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, худалдах, худалдан авах гэрээний төлбөр тооцоог арилжааны банкуудаар дамжуулан гүйцэтгээд байна.

Түүнчлэн биржийн байнгын гишүүдийн тоо 32, итгэмжлэгдсэн агуулахын тоо Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт нийт 25 болжээ.

	2014 оны эхний хагас	2015 оны эхний хагас
Нийт арилжааны дүн (төгрөг)	450,342,980,000.00	298,132,308,600.00
Ноолуурын арилжаа	407,719,557,000.00	271,309,236,600.00
Ноосны арилжаа	7,558,280,000.00	7,060,359,000.00
Завод ноосны арилжаа	26,869,443,000.00	19,458,823,000.00
Тосны ургамлын арилжаа	8,195,700,000.00	-
Хүнсний буудайн арилжаа	-	303,890,000.00
Байнгын гишүүний тоо	30	32
Итгэмжлэгдсэн агуулахын тоо	18	25

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дүрэм, журам, эрх зүйн орчин

Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам болон шимтгэл, хураамж шинэчлэгдэн батлагдав. Биржийн ТУЗ-ийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 11 тоот тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн үйл ажиллагааны ерөнхий журам, мөн өдрийн 12 тоот тогтоолоор “Биржийн арилжааны шимтгэл, хураамжийн хувь хэмжээ”-г шинэчлэн батлууллаа. Түүнчлэн “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Дотоод

журмыг шинэчлэн баталж, “Ажлыг цаг бүртгэл, ашиглалт, үнэлгээний журам”, “Логистик, барааны албаны үйл ажиллагааны журам”, “Байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлт” зэрэг томоохон баримт бичгүүдийг батлан мөрдүүлж байгаа бөгөөд эдгээр эрх зүйн баримт бичгүүд шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан дараах баримт бичгүүдийг боловсруулан баталж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд:

Гэрээний стандарт	Барааны тодорхойлолт	Итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт	Гэрээ
<ul style="list-style-type: none">• Малын спот гэрээ• Бодын хөөврийн спот гэрээ• Хонины ноосны спот гэрээ• Ямааны завод ноосны спот гэрээ• Тэмээний ноосны спот гэрээ• Ноолуурын спот гэрээ• Завод ноосны спот гэрээ	<ul style="list-style-type: none">• Завод ноос• Хүнсний мал бэлтгэл• Ямааны ноолуур• Бодын хөөвөр• Хонины ноос• Тэмээний ноос	<ul style="list-style-type: none">• Самнасан ноолуурын агуулах• Угаасан ноолуурын агуулах• Боловсруулаагүй ноос, ноолуурын агуулах• Ноосны агуулах• Завод ноосны агуулах• Хүнсний буудайн агуулах	<ul style="list-style-type: none">• Агуулахын итгэмжлэл олгох гэрээ• Байнгын бус гишүүний гэрээ

Үндсэн үйл ажиллагаа

Бирж арилжаа зохион байгуулах, клиринг, төлбөр тооцоо гүйцэтгэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд энэ оны эхний хагаст орон нутгийн малчид, тариаланчид биржийн арилжаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор биржийн гишүүдийг биржийн онлайн сүлжээнд холбож орон нутгаас ноолуурын арилжаа зохион байгууллаа. Түүнчлэн хүнсний буудайн спот гэрээг биржээр арилжих боломжтой болсон.

Орон нутгаас цахим арилжааг зохион байгуулав. Хөдөө аж ахуйн биржийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/12 тоот тушаал, 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/26 тоот тушаалыг тус тус үндэслэн Хэнтий, Завхан

аймгаас биржийн арилжааны системд онлайнаар холбогдон ноолуурын арилжааг амжилттай зохион байгууллаа. Орон нутгийн малчид, иргэд биржийн байнгын гишүүн брокерын компани болох “Ханбүргэд Хэнтий” ХХК болон “Бадархундага Оргил” ХХК-уудаар зуучлуулан захиалга өгч биржийн арилжаанд оролцсон.

Хүнсний буудайг биржээр арилжиж эхлэв. Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/135 тоот тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор хүнсний буудайг арилжих бэлтгэл ажлыг хангаж, 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр “Хүнсний буудай”-н анхны арилжааг хийсэн ба нээлтэд Хүнс, хөдөө аж ахуйн сайд

Р.Бурмаа болон холбогдох албаны хүмүүс оролцлоо. Биржээр хүнсний буудайг цавуулаг,

эзлэхүүн жин зэргээс нь хамааруулан 3 ангилан арилжиж байна.

1-р зэрэг



Эзлэхүүн жин 750 г/л-ээс багагүй

Цавуулаг 26.0%-иас багагүй

2-р зэрэг



Эзлэхүүн жин 740 г/л-ээс багагүй

Цавуулаг 23.0-25.9%

3-р зэрэг



Эзлэхүүн жин 710 г/л-ээс багагүй

Цавуулаг 18.0-22.9%

Биржийн гишүүдийн гэрээг шинэчлэн байгуулж, агуулахуудад итгэмжлэл олгов.

Биржийн үйл ажиллагааны ерөнхий журамд заасны дагуу агуулахын итгэмжлэл хүссэн компанийн материалыг хүлээн авч, итгэмжлэлийн шалгуур хангасан эсэхийг газар дээр нь шалгаж, Үлэмж кашимер компанитай

Биржээр арилжигдсан бараанд тодорхойлолт олгов. Хөдөө аж ахуйн биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох журмын дагуу биржээр

Маркетинг, олон нийттэй харилцах

Орон нутагт танилцуулга, хэлэлцүүлэг зохион байгуулав. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах, орон нутгийн түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, иргэд малчдыг бодит мэдээ мэдээллээр хангах, малчдын хоршоог биржийн арилжаанд оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Булган аймгийн ЗДТГ болон Хөдөө, аж ахуйн газраас аймгийн төвд сургалт семинар зохион байгуулж, сумдын МЭҮТ, хоршоод, түүхий эд бэлтгэгчдийн төлөөлөл болох 70 гаруй төлөөлөгчдөд биржийн үйл ажиллагаа, арилжаанд оролцох боломжийн талаар танилцуулж, хэлэлцүүлэг хийв. Мөн Дундговь болон Говьсүмбэр аймгуудын малчдын зөвлөгөөнд оролцож, биржийн арилжаанд

итгэмжлэлийн гэрээ байгуулан ажиллаж байна.

2015 оны эхний хагас жилийн байдлаар шинээр биржийн гишүүн болж элссэн компани байхгүй бөгөөд биржийн гишүүд гишүүнчлэлийн гэрээгээ сунган арилжаанд оролцож байна.

арилжигдсан ноос, ноолуур, хүнсний буудайнд нийт 600 гаруй бараа, түүхий эдийн тодорхойлолтыг олгоод байна.

оролцох боломж, давуу талыг орон нутагт танилцуулсан болно.

Түүнчлэн Сэлэнгэ, Дархан, Хэнтий, Дорнод, Булган, Төв аймгуудад зохион байгуулагдсан “Аймгийн тариаланчдын зөвлөгөөн”-д “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн төлөөлөл оролцож орон нутгийн удирдлагууд, төрийн албан хаагчид болон газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч компани хувь хүмүүст “Хүнсний буудай”-г биржээр хэрхэн арилжих талаар дэлгэрэнгүй танилцуулга хийлээ.

СЗХ-оос зохион байгуулсан чуулга уулзалтад оролцов. СЗХ-оос зохион байгуулсан “Санхүүгийн үйлчилгээний хүртээмж ба орон нутгийн хөгжил” чуулга уулзалт нь Завхан аймгийн Отгон сум болон Улиастай сумуудад тус тус зохион

байгуулагдсан ба уг арга хэмжээнд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Эрдэнэбат оролцож, Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцууллаа.

Сошиал медиа. Мөн биржийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор телевиз, радио, сонин хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн байгууллагуудтай хамтран ажиллаж, биржийн үйл ажиллагаатай холбоотой, мэдээ, мэдээлэл, бараа түүхий эдийн үнийн мэдээллийг цаг тухайд нь өөрийн вэб хуудас, фэйсбүүк, твиттер хуудсуудад хөтлөн явуулж байна.

Биржийн үйл ажиллагааг ирээдүйн арилжаанд оролцогчдод танилцуулав.

Сургалт

Биржээс зохион байгуулах сургалтын хүрээнд “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 5.1.5, “Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-ын 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн 2015 оны 06 дугаар сарын 08-аас 12-ны өдрүүдэд “Брокерын эрх олгох” сургалтыг зохион байгуулж, тэнцсэн суралцагсдад үнэмлэх олгов. Цаашид тус сургалтыг улирал бүр зохион байгуулахаас гадна сургалыг биржийн гишүүд болон олон нийтэд илүү хүртээмжтэй байх үүднээс

Судалгааны ажил

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь фьючерс арилжааг эхлүүлэх, биржээр шинэ бараа бүтээгдэхүүн арилжих боломжийг үргэлж эрэлхийлж судлахын зэрэгцээ бусад өндөр хөгжилтэй улс орнуудын таваарын биржүүдийн спот болон фьючерс гэрээний

Авлигын эсрэг үйл ажиллагаа

“Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс

Улаанбаатар хотын их, дээд сургуулиудын санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага, хөдөө аж ахуйн чиглэлээр суралцагч оюутнуудад зориулан “Хөдөө аж ахуйн бирж”-ийн танилцуулга сургалтыг амжилттай зохион байгуулсан бөгөөд энэхүү танилцуулга, сургалтын зорилго нь оюутнуудад биржийн талаарх мэдээлэл олгох, ирээдүйд мэргэжлийн оролцогчдын тоог нэмэгдүүлэхэд чиглэнэ. Уг арга хэмжээнд МУИС, СЭЗДС, ШУТИС, ХААИС, ХУИС, ИЗИС-уудын нийт 403 оюутан хамрагдсан болно.

Мөн дээрх их, дээд сургуулиудад суралцаж буй оюутнуудаас танилцах болон үйлдвэрлэлийн дадлагаа бирж дээр хийж байгаа бөгөөд холбогдох албанаас удирдамж, заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

онлайнаар танилцуулга, хичээлүүдийг бэлтгэн хүргэхээр зорилт тавиад байна.

БНСУ-ын Хүнс, хөдөө аж ахуй, орон нутгийн хэргийн яамнаас зохион байгуулсан “Малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг мөрдөх тогтолцоо” сэдэвт сургалт 2015 оны 05 дугаар сарын 11-ээс 22-ны өдрүүдэд БНСУ-д зохион байгуулагдсан ба тус сургалтад Логистик, барааны албаны мэргэжилтэн оролцлоо.

арилжаа, клиринг-төлбөр тооцоо, гишүүнчлэл, биржийн эрсдэлийн удирдлага зэргийн судалгааг тогтмол хийж, Монгол улсын хууль, эрх зүйн хүрээнд өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна.

урьдчилан сэргийлэх тухай” хууль тогтоомжийн дагуу эрх бүхий албан тушаалтныг Гүйцэтгэх захирлын тушаалаар

томилж, Биржийн эрх бүхий албан тушаалтнууд хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд нь мэдүүлж, авлига болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ажилтнуудад мэдээлэл өгөх ажлыг зохион байгууллаа.

Худалдан авалттай холбоотой ажлууд

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд заасны дагуу ТӨХ-оос баталсан “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн

Түүнчлэн “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох тайланг улирал бүр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж байна.

2015 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгагдсан төлөвлөгөөт худалдан авалтуудыг гүйцэтгэн ажиллаж байна.

АРИЛЖАА

2015 оны эхний хагас жилд буюу 04 дүгээр сарын 10-ны өдөр биржийн 354 дэх удаагийн арилжаа явагдаж, биржийн арилжааны нийт дүн **нэг их наяд** төгрөгт хүрлээ.

Хөдөө аж ахуйн бирж 2015 оны эхний хагас жилийн байдлаар нийт 94 удаа арилжаа зохион байгуулж, 4754.8 тонн ямааны ноолуур, 52.8 тонн тэмээний ноос, 4236.1 тонн

хонины ноос, 554 тонн хүнсний буудай, 914.1 тонн ямааны завод ноос, 19 тонн тэмээний завод ноос болон 450.1 тонн хонины завод ноосны спот гэрээ тус тус арилжиж нийт 298.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгээд байна. Тайлант хугацаанд өдрийн дундаж арилжааны дүн 3.2 тэрбум төгрөг байлаа.


Ямааны ноолуур	1	Дүн: 271,309,000,000 төг
		Дээд үнэ: 149,500 төг
		Доод үнэ: 50,000 төг
		Хэмжээ: 4,755 тн
Ямааны завод ноос	2	Дүн: 18,871,000,000 төг
		Дээд үнэ: 22,400 төг
		Доод үнэ: 17,000 төг
		Хэмжээ: 914 тн
Хонины ноос	3	Дүн: 6,706,000,000 төг
		Дээд үнэ: 2,197 төг
		Доод үнэ: 1,180 төг
		Хэмжээ: 4,236 тн

Тэмээ, хонины завод ноос	4	Дүн: 588,000,000 төг
		Дээд үнэ: 2,500 төг
		Доод үнэ: 1,200 төг
		Хэмжээ: 469 тн
Тэмээний ноос	5	Дүн: 354,000,000 төг
		Дээд үнэ: 6,700 төг
		Доод үнэ: 6,700 төг
		Хэмжээ: 53 тн
Хүнсний буудай	6	Дүн: 304,000,000 төг
		Дээд үнэ: 565,000 төг
		Доод үнэ: 505,000 төг
		Хэмжээ: 554 тн

Арилжигдсан бараа, түүхий эдийн дүн, хэмжээ, дээд болон доод үнэ

Хамгийн өндөр дүнтэй арилжаа 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдөр 13.7 тэрбум төгрөг байсан бол хамгийн бага дүнтэй арилжаа 2015 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 28.6 сая

төгрөг байлаа. Энэ оны хагас жилийн арилжааны дүнгээс харахад ямааны ноолуур хамгийн их хэмжээ, өндөр дүнтэйгээр арилжигдсан байна.



Арилжааны дүн /сая төгрөгөөр/

Арилжигдсан барааны үнийн дүн /сараар, сая.төг/

	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	Эхний хагас жил
Ямааны ноолуур	871	2,400	4,501	95,946	103,886	63,705	271,309
Тэмээний ноос	177	-	177	-	-	-	354
Хонины ноос	1,170	406	967	1,830	1,598	736	6,706
Ямааны завод ноос	12,870	4,132	1,088	321	460	-	18,871
Тэмээ, хонины завод ноос	-	-	-	94	299	195	588
Хүнсний буудай	-	-	-	276	-	28	304
Нийт	-	-	-	-	-	-	298,132


Арилжигдсан барааны хэмжээ /сараар, тн/


	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	Эхний хагас жил
Ямааны ноолуур	11	31	66	1,633	1,819	1,195	4,755
Тэмээний ноос	26	-	26	-	-	-	53
Хонины ноос	662	259	598	1,120	1,166	431	4,236
Ямааны завод ноос	620	197	52	19	26	-	914
Тэмээ, хонины завод ноос	-	-	-	78	229	163	469
Хүнсний буудай	-	-	-	500	-	54	554
Нийт	-	-	-	-	-	-	298,132

Ноолуурын арилжаа

2015 оны эхний хагас жилийн байдлаар ноолуурын дундаж үнэ 66,305₮ болсон нь өмнө онуудтай харьцуулахад тус тус 1%, 14%-иар буурсан үзүүлэлт боловч биржээр арилжигдсан бусад бараа, түүхий эдийн дундаж үнийн хувьд ерөнхийдөө хэлбэлзэл

багатай байлаа. Энэ оны эхний хагас жилийн байдлаар 4,755 тонн ноолуур арилжигдсан нь энэ жил улсын хэмжээнд бэлтгэсэн ноолуурын 74 орчим хувь нь биржээр арилжигдсан үзүүлэлт болж байгаа юм.






Ноолуурын зах зээлийн үнэ /төгрөгөөр/

Ноосны арилжаа

Бирж анхлан арилжаа явуулж эхэлсэн 2013 онд 1000 тонн хонины ноос арилжигдаж байсан бол өнгөрсөн онд 7600 тонн хонины ноос арилжсан нь улсын хэмжээний хонины ноос бэлтгэлийн 38 хувь нь болж байлаа. Харин 2015 оны эхний хагас жилд 4200 тонн

ноос арилжаанд ороод байна. Бэлтгэсэн ноосны 28.6 хувийг үндэсний үйлдвэрүүд боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, үлдсэн 71.4 хувийг анхан шатны боловсруулалт хийж экспортод гаргадаг байна.




Арилжигдсан хонины ноосны дүн /төгрөгөөр/

Манай улс жилдээ 1200 гаруй тонн тэмээний ноос бэлтгэдэг. Биржийн арилжаагаар 2014 онд 1048 тонн, 2014 онд 1026 тонн ноос арилжигдсан ба энэ оны хагас жилийн

байдлаар 53 тонн тэмээний ноос арилжаанд ороод байна. Байгаль цаг уур, экологийн онцлогоос шалтгаалж тэмээ ноослох хугацааг харилцан адилгүй тогтоож хаврын сүүл, зуны

эхэн сард гол төлөв тэмээний ноос гуужиж эхлэх үед ноослодог. Одоогоор бирж дээр


тэмээний ноосыг 5 төрлөөр, 1 кг-ийг нь 5000-6000 төгрөгөөр арилжиж байна.



Арилжигдсан тэмээний ноосны дүн /төгрөгөөр/

Хүнсэнд хэрэглэсэн болон хорогдсон ямааны арьсыг үйлдвэрийн аргаар зумлаж бэлтгэсэн ноос болох завод ноос нь 12-оос 3 сар хүртэл

бэлтгэгддэг ба одоогоор бирж дээр 1 кг нь 20-23 мянган төгрөгөөр арилжигдаж байна.



Арилжигдсан ямааны завод ноосны дүн /төгрөгөөр/

Хүнсний буудайн арилжаа

Энэ оны 4-р сараас эхлэн биржээр хүнсний буудай арилжигдаж эхэлсэн бөгөөд 2-р

ангиллын буудай 500 тн, 3-р ангиллын буудай 54 тн тус тус арилжигдсан байна.

Хүнсний буудайн үнэ /сараар, төг/

	4-р сар	6-р сар
Дээд үнэ	565,000	510,000
Доод үнэ	505,000	510,000
Дундаж үнэ	552,700	510,000

ГИШҮҮД, АГУУЛАХУУД

Бирж 2015 оны эхний хагас жилийн байдлаар нийт 32 байнгын гишүүн, 25 итгэмжлэгдсэн агуулахтай байна. Биржийн байнгын гишүүн брокерын компани Сэлэнгэ, Сүхбаатар, Дорноговь аймгуудаас бусад аймгуудад

байгаа бол итгэмжлэгдсэн агуулахын хувьд Улаанбаатарт 20, хөдөө орон нутагт 5 агуулах биржийн итгэмжлэл авч үйл ажиллагаа явуулж байна.

Биржийн байнгын гишүүд



Биржийн байнгын гишүүн брокерын компаниудын дэлгэрэнгүй жагсаалт:

№	Компанийн нэр	Биржийн код	Орон нутгийн харъяалал	Арилжих зөвшөөрөлтэй бараа, түүхий эд
1	Бадархундага оргил ХХК	0001	Завхан аймаг	Ноос, Ноолуур, Тосны ургамал / Рапс
2	Хаан нэгдэл ХХК	0002	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур
3	Хөвчийн тал ХХК	0004	Дорнод аймаг	Ноос, Ноолуур, Тосны ургамал / Рапс
4	Ханбүргэд хэнтий ХХК	0005	Хэнтий аймаг	Ноос, Ноолуур, Тосны ургамал / Рапс
5	Ивээлт инэл ХХК	0006	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур
6	Сантланс ХХК	0007	Төв аймаг	Ноос, Ноолуур
7	Хаан тэлмэн ХХК	0008	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур
8	Вүүдсоунд ХХК	0009	Увс аймаг	Ноос, Ноолуур
9	Цэц-Инвест ХХК	0010	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур, Тосны ургамал / Рапс
10	Өлгий түүхий эд ХХК	0011	Баян-Өлгий аймаг	Ноос, Ноолуур
11	Саяанхаан ХХК	0013	Булган аймаг	Ноос, Ноолуур

12	Бурхант таван эрдэнэ ХХК	0014	Дархан-Уул аймаг	Ноос, Ноолуур
13	Баяр плант ХХК	0015	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур
14	Батбилгэх ХХК	0016	Дундговь аймаг	Ноолуур
15	Гурван цаст гал тамга ХХК	0017	Ховд аймаг	Ноос, Ноолуур
16	МЭТУ ХХК	0018	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур, Тосны ургамал / Рапс
17	Мөрөн таван эрдэнэ ХХК	0020	Хөвсгөл аймаг	Ноос, Ноолуур
18	Засагтхан гарьд ХХК	0021	Завхан аймаг	Ноос, Ноолуур
19	Өвөр таван эрдэнийн шим ХХК	0022	Өвөрхангай аймаг	Ноос, Ноолуур, Тосны ургамал / Рапс
20	Бурналасан од ХХК	0023	Өмнөговь аймаг	Ноос, Ноолуур
21	Хонгорын таван эрдэнийн хишиг ХХК	0025	Баянхонгор аймаг	Ноос, Ноолуур
22	Танан дээж трэйд ХХК	0029	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур
23	Увс таван эрдэнийн ундарга ХХК	0030	Увс аймаг	Ноос, Ноолуур
24	Алтан шагай импэкс ХХК	0031	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур, Тосны ургамал / Рапс
25	Өлгий ундарга ХХК	0032	Баян-Өлгий аймаг	Ноолуур
26	Гүүдкомэкс ХХК	0033	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур
27	Стандарт таваар ХХК	0034	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур
28	Батсигнач ХХК	0035	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур
29	Төв таван эрдэнэ ХХК	0036	Төв аймаг	Ноос, Ноолуур
30	Рояал кашимер ХХК	0037	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур
31	Эрхэм сүрэг ХХК	0038	Говь-Алтай аймаг	Ноос, Ноолуур
32	Ийзи плас ХХК	0039	Улаанбаатар хот	Ноос, Ноолуур, Тосны ургамал / Рапс

Итгэмжлэгдсэн агуулахууд

№	Компанийн нэр	Итгэмжлэлийн зориулалт	Итгэмжлэл олгосон шийдвэр	Биржийн код	Орон нутгийн харъяалал
1	Ханбогд кашимер ХХК	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБСХ01	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
2	Ноос ирээдүй ХХК	Ноос, ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБХУ21	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
3	Сор кашемир ХХК	Ноос, ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБСХ07	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
4	Хос гол ХХК	Ноос, ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБСХ16	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
5	Лоро Пьяна Монгол ХХК	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБХУ04	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
6	Монитал ХХК	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБСХ03	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
7	Жин корона ХХК	Ноос, ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБСХ12	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
8	Эм Ди Си Пи ХХК	Ноос, ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБХУ15	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг

9	Ви Си ХХК	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБСХ19	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
10	Эм Эм Жи Капитал ХХК	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБ1501	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
11	Элтон ХХК	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБХУ09	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
12	Инэл кашимер ХХК	Ноос, ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБ0601	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
13	Ньюспэйс ХХК	Ноос, ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБСХ17	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
14	Хаоен үйлдвэр	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УББ305	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
15	Говь ХК	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБХУ01	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
16	Алтай кашмир ХХК	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБХУ08	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
17	Блю скай кашемир ХХК	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБХУ14	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
18	Гоёо ХХК	Ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	УБХУ20	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
19	Жи ЭС Ф ХХК	Ноосны агуулах	2014.11.24 – А/85	УБХУ23	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
20	Үлэмж Кашимер ХХК	Боловсруулаагүй ноос, ноолуур	2015.06.24 – А/32 Гэрээ – 2015.06.29	УБСХ36	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
21	Могол ноос ХХК	Ноосны агуулах	2014.04.07 – А/36	ТӨБТ22	Төв аймаг
22	Ханбүргэд хэнтий ХХК	Ноос, ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	ХЭ0501	Хэнтий аймаг
23	Бадархундага оргил ХХК	Ноос, ноолуурын агуулах	2014.04.07 – А/36	ЗА0101	Завхан аймаг
24	Чойрхайрхан ХХК	Ноосны агуулах	2014.11.24 – А/85	ГСБТ24	Говьсүмбэр аймаг
25	Лидер кашемир ХХК	Ноос, ноолуурын агуулах	2014.11.24 – А/85	ХӨСӨ28	Хөвсгөл аймаг



Хөдөө аж ахуйн бирж

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамж – 37, GB Plaza

Утас: 7011-8779, 7012-8779, 7012-8775, 7012-8776, 7014-8779

Факс: 7013-8779

www.mce.mn